

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 1 дүгээр сарын 22

№ 03

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2018 оны 1 дүгээр сарын 22-ний өдрийн 08 цаг 32 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд удирдаж, хуралд нийт 22 гишүүд оролцож. Аймгийн Засаг даргын орлогч А.Түвшинбат, Орхон сумын Засаг дарга Б.Алтансарнай нар хуралд оролцсонгүй. Хуралдааны ирц 91.66 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Хэлтэс, агентлагийн дарга нар 7 хоногийн ажлын тайлан, холбогдох мэдээ, мэдээлэл, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Аймгийн Засаг даргын орлогч Т.Ганболд:

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
1.	Цагдаагийн газрын мэдээнд дурдагдсан зөрчил гаргаж саатуулагдсан төрийн албан хаагчид болон оюутнуудад яаралтай арга хэмжээ авах	Хууль, эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс
2.	Хууль эрх зүйн хэлтэс захиргааны журмаар зөрчил үүссэн худалдаа, үйлчилгээний газруудад болон 2-оос дээш зөрчил гаргаж байгаа ААНБ-уудад арга хэмжээ авах тухай албан бичиг өгөх	Хууль, эрх зүйн хэлтэс
3.	6 дугаар сард нийтийн орон сууцны 1 давхарт архи, согтууруулах ундаа худалдаалж байгаа аж ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт явуулж дахин гэрчилгээжүүлнэ. Тиймээс хууль, эрх зүйн хэлтэс, МТАлбатай хамтран эртхэн мэдээлэл өгөх	Хууль, эрх зүйн хэлтэс, Мэдээлэл технологийн алба
4.	Санхүүгийн хяналт аудитын албанаас тайлангаа өгөөгүй болон тайлбар хоцроосон байгууллагуудыг дурдлаа. Өмнө нь бас тайлангаа баталгаажуулаагүй ирүүлээгүй байгаа байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нар бүгд хариуцлага тооцогдсон. Энэ удаа энэ зөрчлийг дахин гаргаж байна. Дараагийн шат шатны арга хэмжээг авна шүү. Хэлтэс, агентлагийн дарга нар анхаарах шаардлагатай байна. 2018 ондоо хурал, зөвлөгөөний ирц, үүрэг даалгаврын хэрэгжилтэд анхаарах	Бүх хэлтэс, агентлагууд
5.	Малын өвчлөлийн голомтоос малын гаралтай мах, сүү худалдахаар малчид авчрах вий Постын хяналтад анхаарах,	Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар
6.	Онцгой комисс сумдын өвсний нөөц борлуулахад анхаарах хэрэгтэй байна. Эхний ээлжид ил байгаа өвсний нөөцөө борлуулах шаардлагатай байна. Аймгийн нөөцийн өвс задгай байгаа учраас Хонгор сум далд байгаа өвсөө борлуулахгүйгээр аймгийн өвсний нөөцөөс эхэлж борлуулахаар зохицуулалт хийх	Онцгой байдлын газар

7	Цагаан сарын баяртай холбогдуулан хүнсний худалдаа, мах, сүү, айраг, малын гаралтай бүтээгдэхүүний жижиглэн худалдаа, архи, согтууруулах ундааны худалдаанд хяналт шалгалт хийх, МТАлбатай хамтран сэрэмжлүүлэг, анхааруулгыг тогтмол давтамжтай гаргах	Мэргэжлийн хяналтын газар, Мэдээлэл, технологийн газар
8.	8 цэцэрлэгийн зуухны хөрөнгө мөнгийг БСУГазраас гаргуулах, БСУГазарт хөрөнгө оруулалтын мэргэжилтэн гэж байгаа, цэцэрлэг, сургуулиудын тулгамдсан асуудлаа огт шийдвэрлэхгүй аймаг руу шууд хандаж шийдвэрлүүлэхээ одоо болих хэрэгтэй байна.	Нийгмийн бодлогын хэлтэс
9.	Цахилгааны үнийн талаарх саналаа Яаманд дахин уламжлах, нэг удаагийн хариулт аваад орхихгүй байх	Захирагчийн алба
10.	Цагаан сарын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан, мах, гурил, гурилан бүтээгдэхүүнийг өөр аймгаас оруулахгүй тухай мэдээллээ бусад аймагт албан бичгээр хүргүүлэх, ямар бүтээгдэхүүнээ авчирч манай аймгийн үзэсгэлэн худалдаанд орж болох эсэх талаарх мэдээллээ мөн өгөх шаардлагатай байна.	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
11.	2 сарын 5-наас 6-ны өдрүүдэд үйлдвэр эрхлэгчийн зөвлөгөөнийг зохион байгуулах хэрэгтэй байна. Эртхэн төлөвлөж, зар мэдээлэл өгөх, үйлдвэр эрхлэгчдийн тооллого хийх	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
12.	Орон нутгийн өмчийн газар тайлан, төлөвлөгөө өгөөгүй газруудыг танилцуулах, тендерт оролцож байгаа аж ахуйн нэгж байгууллагуудаас Дарханы байгууллагуудыг дэмжих зөвлөгөө өгөх, Дархан-Уул аймагт хамгаалалтын алба маш олон байдаг гэтэл гадны байгууллага тендер авсан байх юм. Дарханы байгууллагуудад зөвлөгөө чиглэл өгөх хэрэгтэй. Манай Дарханы байгууллагуудаас 56% нь үйл ажиллагаагаа явуулж, 44% нь хаагдсан байна. Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудаа дэмжих бодлогыг барих ёстой.	Орон нутгийн өмчийн газар
13.	Татварын орлогын төлөвлөгөөнд анхаарах авто үзлэгийн шалгалтыг зохион байгуулах, хүн амын орлогын албан татварын буцаалтын талаар иргэдэд мэдээлэл өгөх	Татварын хэлтэс
14.	Ахмадын судалгааг гаргах, Халамжийн павильон барих санхүүжилтаа авч байна уу?. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны багц хэзээ задрах гэж байна. Хэрвээ задрах болж байгаа бол Яам руу хүн явуулах эртхэн уулзаж санхүүжилтыг найдвартай авах хэрэгтэй байна.	Нийгмийн бодлогын хэлтэс
15.	“Эмт наран” уурхайн үйл ажиллагааг анхаарах, одоо өвөлжилт дуусах дөхөж байна. 2 сар хариуцлагатай байх шаардлагатай байна.	Захирагчийн алба
16.	ХШҮДАХэлтэс түвшин тогтоох шалгалтад анхаарах	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
17.	ХЭЗХэлтэс ХАСХОМ-д анхаарах албан хаагчид хугацаанд нь хөрөнгө орлогын мэдүүлгээ бөглөсөн эсэх, сургалт зохион байгуулах хугацаанд нь дуусгах	Хууль, эрх зүйн хэлтэс
18.	Багийн Засаг дарга руу утсаар ярьж шууд зар тарааж дуудах нь буруу Дархан сумын болон сумдын Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж, дамжуулж хурал зөвлөгөөнийг зараа тараах нь зүйтэй	Бүх хэлтэс, агентлагууд

19.	Шатахуун түгээх газруудын үйл ажиллагаанд хууль, эрх зүйн хэлтэс анхаарах шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газраас шалгалт зохион байгуулах, зохион байгуулалттай үнэ нэмж байгаа нь ойлгомжтой байгаа.	Хууль, эрх зүйн хэлтэс
-----	--	------------------------

Хурал 09 цаг 36 минутад дуусав.

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА П.БАЯРСАЙХАН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН А.СУВД-ЭРДЭНЭ

2018 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН
ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2018 оны 01 дүгээр сарын 29-ны өдөр

№ 03

Дархан-Уул аймаг

№	Өгөгдсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн	Хэрэгжилт
2.	Цагдаагийн газрын мэдээнд дурдагдсан зөрчил гаргаж саатуулагдсан төрийн албан хаагчид болон оюутнуудад яаралтай арга хэмжээ авах	Хууль, эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс	2018 оны 01 дүгээр сарын 30 өдөр Цагдаагийн газарт бүртгэгдсэн төрийн байгууллагын албан хаагчдын байгууллага тус бүрт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажлыг зохион байгуулж мэдэгдэл хүргүүллээ.
2.	Хууль эрх зүйн хэлтэс захиргааны журмаар зөрчил гаргасан худалдаа үйлчилгээний газруудад, 2-оос дээш зөрчил гаргаж байгаа ААНБ-уудад арга хэмжээ авах тухай бичиг өгөх	Хууль, эрх зүйн хэлтэс	Тусгай зөвшөөрөлтэй аж, ахуйн нэгж байгууллагуудын тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл, нөхцөл байдал тогтоогдоогүй байхад цуцлах тухай шийдвэр танилцуулах нь Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь заалтыг зөрчих тухай аймгийн Засаг даргын орлогчид танилцуулсан болно.
3.	6 дугаар сард нийтийн орон сууцны 1 давхарт архи, согтууруулах ундаа худалдаалж байгаа аж ахуй нэгж байгууллагуудад хяналт шалгалт явуулж дахин гэрчилгээжүүлнэ. Тиймээс хууль, эрх зүйн хэлтэс, МТАлбатай хамтран эртхэн мэдээлэл өгөх	Хууль, эрх зүйн хэлтэс, Мэдээлэл технологийн алба	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж, ахуй нэгж байгууллагуудын 2017 оны захиргааны зөрчлийн судалгааг гаргах зорилгоор Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газарт албан бичгийг хүргүүлж судалгааг гаргаад байна.
4.	Санхүүгийн хяналт аудитын албанаас тайлангаа өгөөгүй болон тайлбар хоцроосон байгууллагуудыг дурдлаа. Өмнө нь бас тайлангаа баталгаажуулаагүй ирүүлээгүй байгаа байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нар бүгд хариуцлага тооцогдсон. Энэ удаа энэ зөрчлийг дахин гаргаж байна. Дараагийн шат шатны арга хэмжээг авна шүү. Хэлтэс, агентлагийн дарга анхаарах шаардлагатай байна. 2018 ондоо хурал зөвлөгөөний ирц, үүрэг даалгаврын хэрэгжилтэд	Бүх хэлтэс, агентлагууд	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй

	анхаарах		
5.	Малын өвчлөлийн голомтоос малын гаралтай мах, сүү худалдахаар малчид авчрах вий Постын хяналтад анхаарах,	Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
6.	Онцгой комисс сумдын өвсний нөөц борлуулахад анхаарах хэрэгтэй байна. Эхний ээлжид ил байгаа өвсний нөөцөө борлуулах шаардлагатай байна. Аймгийн нөөцийн өвс задгай байгаа учраас Хонгор сум далд байгаа өвсөө борлуулахгүйгээр аймгийн өвсний нөөцөөс эхэлж борлуулахаар зохицуулалт хийе	Онцгой байдлын газар	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
7	Цагаан сарын баяртай холбогдуулан хүнсний худалдаа, мах, сүү, айраг, малын гаралтай бүтээгдэхүүний жижиглэн худалдаа, архи, согтууруулах ундааны худалдаан хяналт шалгалт хийх, МТАлбатай хамтран сэрэмжлүүлэг, анхааруулгыг тогтмол давтамжтай гаргах	Мэргэжлийн хяналтын газар, Мэдээлэл, технологийн газар	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
8.	8 цэцэрлэгийн зуухны хөрөнгө мөнгийг БСУГазраас гаргуулах, БСУГазарт хөрөнгө оруулалтын мэргэжилтэн гэж байгаа, цэцэрлэг, сургуулиудын тулгамдсан асуудлаа огт шийдвэрлэхгүй аймаг руу шууд хандаж шийдвэрлүүлэхээ одоо болих хэрэгтэй байна.	Нийгмийн бодлогын хэлтэс	Цэцэрлэгийн халаалтын зуухны горим алдагдалтай байгаа учир, шаардлагатай засварыг яаралтай хийх талаар гүйцэтгэгч “Хачиган Болор ХХК” зөвлөмж өгөн ажиллаж байна.
9.	Цахилгааны үнийн талаарх саналаа Яаманд дахин уламжлах, нэг удаагийн хариулт аваад орхихгүй байх	Захирагчийн алба	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
10.	Цагаан сарын үзэсгэлэн худалдааг зохион байгуулах гэж байгаатай холбогдуулан, мах, гурил, гурилан бүтээгдэхүүнийг өөр аймгаас оруулахгүй тухай мэдээллээ бусад аймагт албан бичгээр хүргүүлэх, ямар бүтээгдэхүүнээ авчирч манай аймгийн үзэсгэлэн худалдаанд орж болох эсэх талаарх мэдээллээ мөн өгөх шаардлагатай байна.	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс	Цагаан сар-2018 үзэсгэлэн, худалдааг “Эх орны бүтээгдэхүүнээ хэрэглэцгээе” уриан дор 02 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд буюу 5 хоног Залуучууд театрт зохион байгуулна. Өнөөдрийн байдлаар 100 гаруй өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид бүртгүүлээд байна.
11.	2 сарын 5-наас 6-ны өдрүүдэд үйлдвэр эрхлэгчийн зөвлөгөөнийг зохион байгуулах хэрэгтэй байна. Эртхэн төлөвлөж, зар мэдээлэл өгөх, үйлдвэр эрхлэгчдийн	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөл-	Аймгийн үйлдвэрлэгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг 2018-02-06-ны өдөр зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд аймгийн удирдлагууд болон нийт 75

	<p>тооллого хийх</p>	<p>тийн хэлтэс</p>	<p>үйлдвэрлэгчдийн төлөөлөл оролцлоо. Зөвлөгөөнийг нээж аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр аймаг, орон нутгийн жижиг дунд үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжих, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтыг орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс хийх, төр, үйлдвэрлэгчид мэргэжлийн холбоодын уялдааг идэвхижүүлж, хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллахаа илэрхийлэн зөвлөгөөнийг нээлээ. Энэхүү зөвлөгөөнөөр үйлдвэрлэгчдээ түлхүү сонсож тулгамдаж буй асуудал, санал хүсэлтийг зохих түвшинд хүргэж ажиллах, шийдвэрлэх зорилгоор УИХ, ЗГ, Аймгийн ИТХ, Засаг дарга нарт хандаж Зөвлөмж гаргалаа.</p>
<p>12.</p>	<p>Орон нутгийн өмчийн газар тайлан, төлөвлөгөө өгөөгүй газруудыг танилцуулах, тендерт оролцож байгаа аж ахуйн нэгж байгууллагуудаас Дарханы байгууллагуудыг дэмжих зөвлөгөө өгөх, Дархан-Уул аймагт хамгаалалтын алба маш олон байдаг гэтэл гадны байгууллага тендер авсан байх юм. Хэрвээ манай Дарханы байгууллагууд зөвлөгөө чиглэл өгөх хэрэгтэй. Манай Дарханы байгууллагуудаас 56% нь үйл ажиллагаагаа явуулж, 44% нь хаагдсан байна. Орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагуудаа дэмжих бодлогыг барих ёстой.</p>	<p>Орон нутгийн өмчийн газар</p>	<p>Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй</p>
<p>13.</p>	<p>Татварын орлогын төлөвлөгөөнд анхаарах, автын үзлэгийн шалгалтыг зохион байгуулах,</p>	<p>Татварын хэлтэс</p>	<p>Аймгийн ИТХ-р батлагдсан 2018 оны орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний сар, улирал, жилийн хуваарийн дагуу1 сард 2 тэрбум 082,9 сая төгрөг төвлөрүүлэхээс 1 тэрбум 220.8 сая төгрөг төвлөрүүлж 58.6 хувьтай, Улсын төвлөрсөн төсвийн орлогоор сардаа 188,6 сая төгрөг төвлөрүүлэхээс 188.1 сая төгрөг төвлөрч 99.7 хувийн гүйцэтгэлтэй явж байна.Төсвийн орлогыг бүрдүүлэхэд төсвийн</p>

		<p>байгууллагын дулаан,цахилгааны төлбөрийг ДДЦС,Шарын гол ХК-ны татварт/Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татварт 35.8 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татварт 14.3 сая төгрөг, газрын төлбөрт 2.0 сая төгрөг, ус рашаан ашигласны төлбөрт 8.2 сая төгрөг нийт 60.3 сая төгрөг хаалтаар тооцож байна.1 дүгээр сард нийт 90.3 сая төгрөг хаалтаар татварын орлогод орно.</p> <p>АТБӨЯХАТатвар, агаарын бохирдлын төлбөр, замын санг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхтэй холбоотой 01-А/08, 01-А/09 тоот захирамж гарч ажлын хэсгээс бүх л мэдээллийн хэрэгслээр сурталчилан, хэвлэлийн бага хурал хийн онцлог байдлуудыг мэдээлж, өдрийн сонинд байршуулан, Цагдаагийн газар, замын цагдаагийн тасагтай хамтран сар бүр орлогыг жигд төвлрүүлэх тал дээр уулзаж ерөнхий процессоо ярилцаад явж байна. Нэг цэгээс АТҮТөв дээрээс үйлчилгээ үзүүлэх баг ажиллаж эхэлсэн. Дугаарын хязгаарлалттай тул тухайн сард ороогүй тээврийн хэрэгсэлд торгууль ногдуулахаар байгааг ЛХА, Ди би Эс телевизийн урсдаг зар, FM-үүдээр өдөрт 48 удаа явуулж, хэвлэлийнхэнд 4 удаа мэдээлэл өгч ажиллаж байна. Одоо нийтэд харагдах орчинг бүрдүүлэх зорилгоор хэвлэлийн анонсуудыг захиалж байрлуулахаар ажиллаж байна. Мөн замын цагдаагийн газар, татварын хэлтэс тус үзлэгийн явцын талаар болон цаашид юунд анхаарах талаар орон нутгийн мэдээллийн хэрэгслээр мэдээллэсэн.</p>
14.	Хүн амын орлогын албан татварын буцаалтын талаар иргэдэд мэдээлэл өгөх, татварын хууль тогтоомжуудыг сурталчилах	<p>Татварын шинэчлэгдсэн хууль, тогтоомж,татварын тайлан хүлээн авахтай холбогдуулан иргэдэд сайн мэдээллэх. Татварын хэлтэс Татварын албанаас мэдээллийн хэрэгсэлээр цацагдаж байгаа хуулийг буруу тайлбарлан сошиал ертөнцөд сурталчилж байгаад 2 удаа ажлын хэсэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр ААНОАТТХууль, ХХОАТТХууль,МУ-ын Сангийн</p>

		<p>сайдын 379 тоот тушаалын хүрээнд шинэчлэн найруулагдсан хуулийн үнэн зөв байдлыг жишээн дээр тайлбарлан, Газар эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэний орлогод албан татварыг хэрхэн ногдуулах, татварын ногдлыг тодорхойлох аргачлал, ХХОАТТХ-ийн дагуу газрын дуудлага худалдааны үнийг суурь болгон холбогдох итгэлцүүрээр бүсчлэн тогтоож 10 хувийн татвар авах, эрх борлуулсаны орлогод 30 хувиар татвар ногдуулах зэрэг сегментүүдийг мэдээлж, социал мэдээллийн баазад байрлуулсан. Цаашид ч шинэчлэн найруулагдан гарсан хуулиудыг нийтэд сурталчилан таниулах үйл ажиллагааг тогтмол хийх болно. 2018 оны эхнээс орон нутгийн DBS, LHA, Аа Жи Би, Дархан мэдээллийн алба телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ хийж, гэрээний дагуу ажиллаж байна.</p> <p>ХХОАТ-ЫН тухай, ААНОАТ-ын тухай хуульд орсон өөрчлөлт, ХХОАТ хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах, бүрдүүлэх материалын талаар мэдээлэл хийж, хэвлэлийн бага хурал хийж зохион байгуулсан. Хэвлэлийн бага хуралд ТУАБ Д.Гантөмөр, ТУАБ Х.Оюунцэцэг, ТУБ Р.Энхтуяа нар оролцсон.</p> <p>ХХОАТ-ын тайлан хүлээн авах, хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдах иргэдийн бүрдүүлэх материал болон НӨАТУС-ийн хэрэгжилтийн талаар, системд бүртгүүлэх, баталгаажуулалт хийлгэх, мэдээллийн зөрүүтэй иргэдэд зориулан ТУАБ Х.Оюунцэцэг DBS, LHA телевизүүдээр мэдээлэл хийсэн байна. Мөн цаг үеийн байдлаар телевизийн мэдээнд 2 удаа Татварын хэлтсийн нэг цэгийн үйлчилгээнээс газар дээр нь мэдээ өгсөн.</p> <p>АТБӨЯХ-ийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөх, авто тээврийн улсын үзлэгтэй холбоотой хэвлэлийн бага хурал хийсэн. Хуралд хэлтсийн дарга Ж.Баярт-од, ТУАБ Д.Гантөмөр,</p>
--	--	---

			<p>Хөрөнгө оруулалт хөгжлийн бодого төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Баясгалан, ажилтан Э.Идэрболд нар оролцов.</p> <p>Дарханы мэдээ сонины 2018 оны 1 дүгээр сарын 24 дугаарт ХХОАТ тайлан ирүүлэх, хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдах талаар нийтлэл гаргасан.</p> <p>Цэргийн ангийн 330 дугаар ангийн 220 албан хаагчид, Дархан Замын-1 байгууллагын 46 иргэнд ТЭХ, ХХОАТ тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, НӨАТ буцаан олголт, анхаарах зүйлсийн талаар сургалт хийсэн.</p>
15.	Ахмадын судалгааг гаргах, Халамжийн павильон барих санхүүжилтаа авч байна уу?. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны багц хэзээ задрах гэж байна. Хэрвээ задрах болж байгаа бол Яам руу хүн явуулах эртхэн уулзаж санхүүжилтыг найдвартай авах хэрэгтэй байна.	Нийгмийн бодлогын хэлтэс	Үүрэг даалгаврын хэрэгжилт ирүүлээгүй
17.	“Эмт наран” ОНӨААТҮГ үйл ажиллагааг анхаарах, одоо өвөлжилт дуусах дөхөж байна. 2 сар хариуцлагатай байх шаардлагатай байна.	Захирагчийн алба	“Эмт наран” ОНӨААТҮГазрын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Нүүрсний 17 хоногийн нөөцтэй байна.
18.	ХШҮДАХэлтэс түвшин тогтоох шалгалтад анхаарах	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	ЗДТГ-ын албан хаагдаас Тамгын газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2 удаагийн шалгалтыг зохион байгууллаа.
19.	ХЭЗХэлтэс ХАСХОМ-д анхаарах албан хаагчид хугацаанд нь орлогын мэдүүлгээ бөглөсөн эсэх, сургалт зохион байгуулах хугацаанд нь дуусгах	Хууль, эрх зүйн хэлтэс	<p>Дархан-Уул амйгийн ЗДТГ-ын болон түүний харьяа 12 байгууллага 187 албан тушаалтан ХАСХОМ гаргахаас мэдүүлэг гаргагч 22 хүн баталгаажуулалт хэлтсээс 12 ЭБАТ хүлээн авч баталгаажуулалт хийсэн байна.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Аймгийн ЗДТГ-т 92 албан • хаагч гаргахаас: <ul style="list-style-type: none"> - Мэдүүлэг гаргагч баталгаажуулсан-1 -ЭБАТ ХАСХОМ хүлээн авч баталгаажуулсан байна • Эрүүл мэндийн газар: <ul style="list-style-type: none"> - мэдүүлэг гаргагч баталгаажуулсан-2

			<ul style="list-style-type: none"> • БСУГазар: -мэдүүлэг гаргагч-14 баталагаажуулсан -ЭБАТ баталгаажуулсан-7 байна
20.	Багийн Засаг дарга руу утсаар ярьж шууд зар тарааж дуудах нь буруу Дархан сумын болон сумдын Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж, дамжуулж хурал зөвлөгөөний зараа тараах нь зүйтэй	Бүх хэлтэс, агентлагууд	Багийн Засаг дарга нарыг хурал зөвлөгөөнд хамруулахдаа Дархан сумын ЗДТГазарт мэдэгдэж дамжуулж байх талаар анхаарч ажиллаж байна.
21.	Шатахуун түгээх газруудын үйл ажиллагаанд хууль, эрх зүйн хэлтэс анхаарах шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газраас шалгалт зохион байгуулах, зохион байгуулалттай үнэ нэмж байгаа нь ойлгомжтой байгаа.	Хууль, эрх зүйн хэлтэс	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирсэн 2018 оны 01 дүгээр сарын 09-ны 1/43 дугаарын мэдэгдлийн дагуу шатахууны хязгаралалт хийж, үнийг нэмэгдүүлсэн тохиолдолд Өрсөлдөөний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авхийг анхааруулсан.

ХЯНАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

А.СУВД-ЭРДЭНЭ